

ХЯНАЛТЫН КАМЕРЫН ТӨХӨӨРӨМЖ БАЙРШУУЛАХ, АШИГЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэ журмын зорилго нь Нийслэлийн засаг захиргааны байруудын өмч хөрөнгө хамгаалах, аюулгүй байдлыг хангах зорилгоор хяналтын камер байршуулах, ашиглахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэ журам нь Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль тэдгээртэй нийцүүлэн гаргасан журам, Монгол Улсын олон улсын гэрээ, ISO/IEC 27001, ISO/IEC 27701 стандартад нийцсэн байна.
- 1.3. Хяналтын камерын дүрсний системд хадгалагдаж байгаа хувь хүний болон мэдээллийг хуульд зааснаас бусад тохиолдолд үзүүлэх, сонсох, хуулбарлан өгөхийг хориглоно.
- 1.4. Хяналтын камерын ашиглалт, засвар үйлчилгээ, боловсон хүч, хэвийн үйл ажиллагааг Нийтлэг үйлчилгээний газрын инженерийн байгууламжийн ашиглалт, үйлчилгээний алба хариуцан хэрэгжүүлнэ.

Хоёр. Бичлэгийн төхөөрөмж байршуулахад тавигдах шаардлага

- 2.1. Дүрс бичлэгийн техник, хэрэгсэл Олон улсын IP67 стандартад нийцэхээс гадна дараах шаардлагыг хангасан байна.
 - 2.1.1. Шилэн кабелийн холболтын үйлчилгээ байгууллагад холболт хийгдсэн, бие даасан дэд сүлжээ техникийн өрөөтэй байх;
 - 2.1.2. Дүрс бичлэгийн камерын нягтаршил 40mp- ээс багагүй хүний царай зүс, гадаад дүр төрх содон шинж тэмдгийг татаж томруулах боломжтой байх;
 - 2.1.3. Цаг агаарын нөхцөлд -40 +40 хэмд тэсвэртэй байх;
 - 2.1.4. Камерын бичлэг төхөөрөмжийн тохиргооны горим нь англи хэл болон монгол хэл дээр байх;
 - 2.1.5. Бичлэгийн тоног, төхөөрөмж нь 3 хоногоос багагүй хугацаанд хяналтын камерын бичлэг, мэдээллийг хадгалах багтаамжтай байх;

Гурав. Хяналтын камерын төхөөрөмж байршуулах, ашиглах

- 3.1. Бичлэгийн төхөөрөмж байршуулахад дараах шаардлагыг хангасан байна.
 - 3.1.1. Ажлын байранд хүний болон мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах, байгууллагын эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор тавигдсан байна.

- 3.1.2. Нийслэлийн Засаг захиргааны байрууд байрлаж буй төрийн байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор орох гарах хэсэг болон нийтийн эзэмшлийн талбайд хяналтын камерыг заавал байршуулна.
- 3.1.3. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд заасны дагуу хяналтын камерын бичлэгийн төхөөрөмжийг зөвшөөрөгдсөн хэсэгт байршуулж ашиглана.
- 3.2. Бичлэгийн төхөөрөмж ашиглахад дараах шаардлагыг хангасан байна.
 - 3.2.1. Дүрсний бичлэгт мэдээллийн эзнээс бусад хүний хувийн мэдээлэл байгаа тохиолдолд дүрсний бичлэгийг үзүүлэх, хуулбарлаж өгөхийг хориглоно.
 - 3.2.2. Дүрсний бичлэгийн төхөөрөмжийг ариун цэврийн өрөө, хувцас солих өрөө, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх өрөө зэрэг хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхэд илтэд халдахаар байршилд дүрсний бичлэгийн төхөөрөмж байршуулахгүй.
 - 3.2.3. Нийслэлийн засаг захиргааны байруудын хяналтын камерын төхөөрөмжийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хянагч оператор, ашиглалт, техникийн хяналт (тоног, төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, програм хангамж)-ыг мэдээлэл холбоо, дохиоллын инженер тус тус хариуцан ажиллана.
 - 3.2.4. Хянагч оператор нь хяналтын камерын төхөөрөмжид гарсан аливаа техникийн болон програм хангамжийн алдаа, доголдол үүссэн тохиолдолд нэн даруй мэдээлэл холбоо, дохиоллын инженерт мэдэгдэнэ.
 - 3.2.5. Нийт байруудын хэмжээнд ашиглаж буй хяналтын камерын бичлэгийг шүүх болон хуулбарлахдаа цагдаагийн байгууллагаас ирсэн албан хүсэлт эсхүл иргэний тавьсан хүсэлтийг байгууллагын удирдлагад уламжлан зөвшөөрлийн дагуу бичлэгийн санд хадгалагдсан бичлэгийг үзүүлэх, шаардлагатай тохиолдолд флаш диск, зөөврийн хард дискэн дээр хуулбарлаж өгнө.
 - 3.2.6. Тоног төхөөрөмжийн холболт тохиргоог өөрчлөх, хадгалагдаж буй мэдээллийг зөвшөөрөлгүйгээр ил болгох, хуулбарлах, өөрчлөх, устгах, хандалтыг таслах, мэдээллийн системийн үйл ажиллагааг тасалдуулахыг хориглоно.
- 3.3. Инженерийн албаны мэдээлэл, технологи хариуцсан ажилтан жил тутамд нэг удаа төлөвлөгөөт техникийн үзлэг шалгалт хийж, хяналтын камерын системийн тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллана.

Дөрөв. Хариуцлага

- 4.1. Энэхүү журмыг зөрчсөн ажилтан, албан хаагчдад холбогдох хууль, дүрэм, журмын дагуу хариуцлага хүлээлгэж буруутай этгээдээр хохирлыг нөхөн төлүүлнэ.